

АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
I.1 Төлийн талаарх мэдээлэл	3
I.2 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц	4
I.3 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа	4
I.4 Уурхайн ажиллах горим	4
I.5 Баяжуулалтын технологи	5
I.6 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг	6
II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8
II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд	8
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	13
III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	13
III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	13
III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	14
III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	14
IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	16
IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	20
IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	21
IV.4 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө	23
IV.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
IV.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	23
IV.7 Хог хаягдлын менежмент	26
IV.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	28
V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1 Төслийн талбайн байршил.....	3
Зураг № 2 Угаан баяжуулах технологийн схем.....	5
Зураг № 3. Уурхайн цахилгаан хангамжийн схем.....	6
Зураг № 4. Төслийн талбайд байрлуулсан хогийн бункер.....	7
Зураг № 5 Ургамал сумын агаарын температурын норм.....	9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Талбайн газар зүйн солбицол.....	3
Хүснэгт № 2. Уурхайн ажиллах горим.....	5
Хүснэгт № 3 Төслийн талбайн ажилчдын хотхоны усны хэрэглээ.....	7
Хүснэгт № 4 Ил уурхайн усны хэрэглээ.....	7
Хүснэгт № 5 Баяжуулах хэсгийн усны хэрэглээ.....	8
Хүснэгт № 6 Унд ахуйн усны хэрэглээ.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт № 7 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	13
Хүснэгт № 8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт № 9 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт № 10 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	22
Хүснэгт № 11 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт № 12 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө.....	27
Хүснэгт № 13 Орчны шинжилгээний хөтөлбөр.....	30
Хүснэгт № 14. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ.....	34
Хүснэгт № 15 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал.....	35
Хүснэгт № 16 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	36


I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төлийн талаарх мэдээлэл

Төслийн байршил: “Од” нэртэй MV-020628 дугаартай тусгай зөвшөөрлийн талбай нь Завхан аймгийн Ургамал сумын нутагт, байр зүйн зургийн M-46-128 дугаартай хавтгайд байрлана.

MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газар нь 1639.24 га эзэлдэг бөгөөд талбай нь ерөнхийдөө урдаас хойш 4.9 км, баруунаас зүүн тийш 5.1 км хэмжээтэй.

MV-020628 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай хайгуул явуулсан талбай нь засаг захиргааны хувьд Завхан аймгийн Ургамал сумын нутагт хамаарна. Ургамал сумын төвөөс баруун урагш 27 км, Улаанбаатар хотоос баруун хойш 1250 гаруй км, Завхан аймгийн төвөөс БХ 226 орчим км зайд байдаг.



Зураг № 1 Төслийн талбайн байршил
Хүснэгт № 1 Талбайн газар зүйн солбицол

Талбайн булангийн цэгүүд	Өргөрөг	Уртраг
1	93° 59' 50.00"	48° 24' 20.40"
2	93° 59' 50.00"	48° 21' 30.30"
3	93° 59' 42.60"	48° 21' 30.30"
4	93° 59' 39.30"	48° 21' 37.30"
5	93° 59' 34.84"	48° 21' 37.24"
6	93° 57' 30.00"	48° 21' 37.24"
7	93° 57' 30.00"	48° 23' 30.00"
8	93° 56' 30.00"	48° 23' 30.00"
9	93° 56' 30.00"	48° 24' 14.60"
10	93° 56' 44.80"	48° 24' 14.60"
11	93° 56' 50.50"	48° 24' 15.00"
12	93° 56' 50.50"	48° 24' 20.40"

Төсөл хэрэгжүүлэгч: “Форсголд Майнинг” ХХК нь Монгол улсын 9011622079 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоот. Утас:77100909

I.2 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц

Ордын нөөц: Тус ордын MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлт талбайн үлдэгдэл нөөц 2022 оны 01-р сарын 01-ний өдрийн байдлаар ордын нөөц бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 1,035.32 мг/м³ алтны дундаж агуулгатай 232.79 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 240.41 кг, алт (химийн цэврээр) 215.91 кг нөөц байна. Ил уурхайг ашиглах явцад олборлолтын үеийн хаягдал болон тээвэрлэлтийн үеийн хаягдал үүсэхгүй байхаар тооцоход 826.80 мг/м³ алтны агуулгатай 264.45 мян.м³ үйлдвэрлэлийн нөөц ба үүнээс 81.2%-ийг буюу 214.52 мян.м³ бодитой (B) зэрэглэлийн нөөц, 18.8%-ийг буюу 49.93 мян.м³ боломжтой (C) зэрэглэлийн нөөц тус тус эзэлж байна. Энэхүү нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын хавсралтын 3.1.2-н заалтын дагуу магадласан үйлдвэрийн (B') нөөц рүү шилжүүлэв. Ашиглалтын MV-020628 тоот тусгай зөвшөөрөлт талбайн хөрсний зузаан их болон алтны агуулга бага хэсэгт эдийн засгийн хувьд үр ашиггүй нөхцөлөөс хамааран ордын бодитой болон боломжтой (B+C) нөөцийн зэрэглэлээр 613.52 мг/м³ алтны дундаж агуулгатай 36.44 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 22.36 кг, алт (химийн цэврээр) 20.02 кг нөөц ил уурхайн гадна үлдэж байна. Мөн тус ордын тусгай зөвшөөрлийн хилийн гадна буюу XV-017729 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлийн талбайд 2022 оны 01-р сарын 01-ний өдрийн байдлаар бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 699.44 мг/м³ алтны дундаж агуулгатай 30.23 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 21.15 кг, алт (химийн цэврээр) 18.95 кг нөөц байна.

I.3 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа

Төсөл захиалагчаас ирүүлсэн ТЭЗҮ боловсруулах техникийн ажлын даалгавар, угаан баяжуулах хэсгийн хүчин чадалд тулгуурлан ил уурхайн хүчин чадлыг 130.0 мян.м³/жил, хоногт 612 м³ элс олборлохоор төлөвлөв. Уг хүчин чадалд тулгуурлан ордын ашиглалтын хугацааг тооцоолоход 3 жил байна.

I.4 Уурхайн ажиллах горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн олборлолт болон элс угаалтын ажлыг 4-р сараас 10-р сар хүртэл үргэлжлэлхээр тооцоолж ТЭЗҮ(тодотгол-I)-ийг боловсруулав. Ил уурхайн горимыг дараах хүснэгтээр үзүүлэв.


Хүснэгт № 2. Уурхайн ажиллах горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн календарь хоног	хоног	365
2	Төлөвлөгөөт засварын хоног	хоног	18
3	Төлөвлөгөөт сул зогсолтын хоног	хоног	151
4	Жилд ажиллах бодит хоног	хоног	196
5	Жид ажиллах календарь цаг	цаг	8,760
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
8	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	24
9	Жилд ажиллах бодит хугацаа	цаг	3,920
10	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент	-	0.76
11	Ээлж солилт (цайны цаг, түлш цэнэглэлт, тосолгоо, засвар үйлчилгээ)	цаг	1.0
12	Ээлж солилт (ээлж солилт)	цаг	1.0
13	Хоногт ажиллах бодит цаг	цаг	20
14	Цаг ашиглалтын коэффициент	-	0.83

I.5 Баяжуулалтын технологи

Цагаан толгой ордын дээж нь хялбар угаагдах ангилалд хамаарагдаж байна. Баяжуулах хэсэгт тоног төхөөрөмжүүд нэг шугамаар байрлан ажиллана. Элс хүлээн авах бункерт алт агуулагч элсийг утгуурт ачигчаар ачин шигшүүрт оруулж 20 мм шигшүүрээр угаан ангилна.


Шигшүүрээс гарсан 20 мм-ээс бага хэмжээтэй элсийг шлюзээр баяжуулна. 20 мм-ээс том хэмжээтэй элсийг гаалийн овоолгод хураана. Шлюзээс гарсан баяжмалыг гүйцээн баяжуулах хэсэгт сэгсрэх ширээгээр баяжуулан шлихийн алтыг гаргаж авна. Гүйцээн баяжуулах хэсгийн сэгсрэх ширээний хаягдал өөрийн урсгалаар хаягдалын санд хуримтлагдана. Тунах нууранд хуримтлагдсан усыг цэвэршүүлэх далан руу тунаан технологийн эргэлтийн ус болгон дахин ашиглана. Элс угаан баяжуулах хэсгийн технологийн схемийг дор харуулав.



Зураг № 2 Угаан баяжуулах технологийн схем

I.6 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчээ дизель үүсгүүрээр шийдсэн. Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгч нь уурхайн тосгоноос гадна ил уурхайн гэрэлтүүлэг, ус хангамжийн хэсэг, элс угаан баяжуулах цех зэрэг байх болно. Мөн түүнээс гадна ашиглалтын туршид засварын газар, шатахуун түгээгүүр зэрэг хэрэглэгчид цахилгаан эрчим хүч хэрэглэнэ.



Зураг № 3. Уурхайн цахилгаан хангамжийн схем

Хог хаягдал: Төслийн талбайгаас гарах хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэгт цуглуулан авч Завхан аймгийн Ургамал сумын ЗДТГ-тай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлыг нэгдсэн цэг рүү ачуулна.

“Цагаан толгой” алтны шороон ордын хэмжээнд ахуйн гаралтай, үйлдвэрийн гаралтай (засвар үйлчилгээнээс гарах хаягдал) гэсэн 2 төрлийн хог хаягдал гардаг. Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхин дор, ажилчдын гэр байрнаас 100 м зайд байрлуулсан.

Хог хаягдлын цэгийг байгуулахдаа хатуу, шингэнээр нь ялган хаяж байхаар төлөвлөсөн бөнөөд ингэхдээ мөн дахин ашиглагдах, эс ашиглагдахаар нь ялгаж байна.



Зураг № 4. Төслийн талбайд байрлуулсан хогийн бункер

Усан хангамж: Уурхайн усан хангамжийг гүний худгаар хангах юм.

Унд ахуйн ус: Нэг хүний хоногийн усны хэрэглээний нормыг БОНХАЖЯ–ны 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалын хавсралт 12-т заасан ус хэрэглээгээр “Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр” гэсэн нөхцлийг сонгон авч нэг хүний өдөрт хэрэглэх усны нормыг 80 литр байна гэж тооцов. Ундны ба ахуйн хэрэглээний усны хэмжээг уурхайн хүчин чадлын өсөлттэй уялдуулан уурхайд туслан гүйцэтгэгчид, хяналт шалгалт, гэр бүлийн хүмүүс түр ирэх зэргийг тооцоолон үзэхэд уурхайд 70 хүртэл хүн амьдран суух болно.

Хүснэгт № 3 Төслийн талбайн ажилчдын хотхоны усны хэрэглээ

Уурхайн тосгоны усны хэрэглээ

Усны норм	Нийт ажилчид	Уурхайн ажиллах хоног	Хоногт хэрэглэх усны хэмжээ	Нийт ус хэрэглээ
80 литр	70 хүн	196 хоног *3 жил	5600 литр буюу 5.6 м ³	1096.4 м ³ /жил
Энэхүү уурхайн нь 3 жил ажиллах хугацаандаа 3292.8 м ³ буюу 3.29 мян.м ³ усыг унд ахуйд ашиглах тооцоолол гарлаа.				

Зам талбайн усалгаа: Ил уурхайд шаардлагатай технологийн ус хангамжид уурхайн дотоод замын тоос дарах, ногоон байгууламж, талбайн усалгаа болон тоног тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай усны хэрэглээ багтана. Тооцоогоор орд ашиглалтын хугацаанд ойролцоогоор 17.2 мян.м³ усыг зам талбайн усалгаанд ашиглахаар байна.

Хүснэгт № 4 Ил уурхайн усны хэрэглээ

Орд ашиглалтын жил	Замын хэмжээ			Хоногт услах тоо, ш	Жилд услах тоо, ш	Усны зарцуулалт	
	Усалгааны замын урт, м	Зорчих хэсгийн өргөн, м	Талбай, м ²			Норм, л/м ²	Жилд хэрэглэх усны хэмжээ, м ³

1-р жил	4,610.00	10	46,100.00	1	56	2	5,163.20
2-р жил	5,380.00	10	53,800.00	1	56	2	6,025.60
3-р жил	5,410.00	10	54,100.00	1	56	2	6,059.20
Нийт							17,248.00

Баяжуулах хэсгийн усны хэрэглээ: Ордын ойр орчимд гүний худгууд гарсан бөгөөд эдгээрийн дундаж гүн 65 метр орчим гүнтэй худгууд тогтоогдсон. Иймд уурхайн усны нөөцийг гүний худгийн байгууламжаар бүрдүүлэн үйлдвэрлэлийн болон ундны усны хэрэглээгээ хангахаар төлөвлөсөн. Үйлдвэрлэлд шаардлагатай нэмэлт усыг худгийн усаар хангахаар төлөвлөсөн ба уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд байрлах үүсмэл нууруудыг ашиглахаар төлөвлөсөн. Баяжуулах технологийн шат дамжлагаас гарах технологийн усыг баяжуулах цехэд дахин ашиглана. Технологийн тооцоогоор 1 м³ элс угаахад 4 м³ технологийн ус зарцуулна.

Хүснэгт № 5 Баяжуулах хэсгийн усны хэрэглээ

Элс угаан баяжуулах хэсгийн усны хэрэглээ	Баяжуулах элсний хэмжээ, мян.м3	Ус хэрэглээний норм 4м ³	Технологийн ус ашиглалтын коэффициент, %	Эргэлтийн усны хэмжээ, 73%	Шаардлагатай цэвэр усны хэмжээ, мян.м3
1-р жил	32410.73	129642.9	73	94639.33	35003.59
2-р жил	108102.53	432410.2	73	315659.4	116750.7
3-р жил	123938.34	495753.4	73	361900	133853.4
Нийт	264451.6	1057806.0	73	772198.7	285607.7

II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: “Цагаан толгой” алтны шороон ордын уурхай нь физик газарзүйн мужлалаараа Монгол орны баруун хойд хэсэгт Их нууруудын хотгорын мужид байрлана.


Уур амьсгал: Завхан аймаг нь Монголын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн мужид багтана. Хамгийн их халуун /30⁰C ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -30-40 хэм байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.

II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Завхан аймаг 82 мянган хавтгай дөрвөлжин километр нутагтай. Хангайн нуруу түүний ноён оргил Отгонтэнгэр /4031м/, Хангайн нуруунаас салбарласан

далайн түвшнээс 2500-3100м өргөгдсөн Ганц, Загастай , Дахт ,Солонгот, Халзан Согоот зэрэг сүрлэг өндөр уулс даваануутай.

Хамгийн их халуун /30°C ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -30-40 хэм байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.



Зураг № 5 Ургамал сумын агаарын температурын норм

Агаарын температур: Завхан аймгийн нийт нутагт жилийн дундаж салхины хурд ууландаа 2.0м/с, говь хээрт 3.1м/с хүрдэг. Ялангуяа хавартаа салхи ихтэй байдаг. 15м/с –ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо олон жилийн дунджаар 7-22 байна. Салхины хамгийн их хурд 20-40м/с хүрдэг байна. Шороон шуургатай өдрийн тоо уулархаг болон тал хээрийн бүс нутгаар 29-76 хоног. Харин Улиастай, Дөрвөлжин сумдын нутгаар 80-105 хоног байдаг байна. Өвөл, зунд салхины зонхилох чиглэл солигдож хавар, намар шилжилтийн байдалтай байх боловч орчны урсгал, газар нутгийн нөлөөнөөс өвөрмөц байдалтай байдаг.

Агаарын дундаж температур олон жилийн дунджаас 1.2 градусаар дулаарсан цаашид дулааралтын эрчимшил нэмэгдэнэ. Агаарын харьцангуй чийгшил 30 ба түүнээс бага байх өдрийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Хур борооны шинж байдал өөрчлөгдөж зүс бороо цөөрч харин аадар бороо орох тохиолдол ихэссэн. Хүчтэй салхи, шороон шуургатай хоногийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс бид салбар бүрт, иргэн бүр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эерэг дадлыг бий болгох, тухайн газар нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд мод тарих, ногооруулах, ажлыг эрчимтэй хийх нь чухал юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийг орон нутагтаа, сум бүр ажил хэрэг болгож үр дүнтэй хэрэгжүүлэх нь

уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасахад маш чухал нөлөөтэй юм гэдгийг онцолмоор байна.

Агаарын температур нь аливаа нутгийн уур амьсгалын үндсэн шинжийг илтгэгч гол үзүүлэлт болдог. Олон жилийн агаарын температур 0.7 градусаас хасах 6.9 градус хэлбэлзэнэ. Өөрөөр хэлбэл жилийн дундаж температурын агууриг 7.6 градус болж байна. Жилийн дундаж агаарын температур аймгийн нутгийн баруун, баруун өмнөөс зүүн, зүүн хойшоо хүйтэрсэн тархалттай байна. Жилийн хүйтэн сар нь аль ч нутагтаа нэгдүгээр сар байдаг. Тухайлбал, аймгийн хойд болон зүүн хэсгээр сарын дундаж температур 28-32 градус хүрч, хахир хүйтэн өвөл болдог байна. Зарим хүйтэн өвөл Хангайн нуруу, Тарвагатай, Булнай, Тагнын нурууны сав нутгаар 49-56 градус хүрч хүйтэрдэг. Харин жилийн дулаан сар нь долоодугаар сар байх бөгөөд хамгийн дулаан нь Завхан голын дагуу Монгол элсний ар орчим болон их нуурын хотгорын сав орчмоор 17-21 градус бусад нутгаар 14-18 градус дулаан байдаг. Зуны улиралд хөрсний гадаргад 54-68 градус хүртэл халдаг учраас хөрсний гадаргын температурын хэлбэлзэл бүр ч их буюу 110-127 байдаг.

Хөрсөн бүрхэвч: Хөрсний ерөнхий шинж нь ялзмагаар ядмаг карбонатжилт өндөртэй, ус чийгээр дутагдалтай нимгэн бор хөрс болно. Хөрс нь шаварлаг, элсэрхэг, сайргархаг, дайргархаг найрлагатай бөгөөд эдгээр нь өөр өөрийн бүрэлдэх орчинтой байна. Хөндий хотгорын төв хэсгээр шаварлаг, мараалаг хөрс тохиолдох ба сайргархаг дайргархаг бор хөрс нь ил гарсан хад чулуу бүхий толгой, бэл хормойгоор нимгэн бүрхэвч үүсгэж байдаг. Уулсын өндөрлөг газруудаар элгэн хүрэн өнгийн нарийн мөхлөгт хөрс ховроор тохиолддог онцлогтой. Орон нутаг нь салхи, хуурайшилт ихтэй учир элэгдлийн гадаргуутай бөгөөд хөрс нь хийсэж зулгарах нөхцөлтэй юм.

Гадаргын ерөнхий хэлбэр дүрсийн хувьд орой хэсгээрээ хадархаг нам уулс болон түүний энгэр, бэлийн системийг хамран төслийн талбайн байрших бөгөөд хөрсний үүсвэрийн үйл явцад хажуугийн зөөгдлийн үйл явц голчлон оролцох учир хөрс үүсгэгч эх чулуулаг нь делюви, пролювийн хайрган хурдас дээр тогтворжсон нимгэн ялзмагт давхаргатай, сайр чулуурхаг, уулын хээрийн хар хүрэн хэв шинжийн хөрс зонхилон тархсан байна (Д.Доржготов, 2003).

Хөрсний ерөнхий шинж нь ялзмагаар ядмаг карбонатжилт өндөртэй, ус чийгээр дутагдалтай нимгэн бор хөрс болно. Хөрс нь шаварлаг, элсэрхэг, сайргархаг, дайргархаг найрлагатай бөгөөд эдгээр нь өөр өөрийн бүрэлдэх орчинтой байна.

Амьтны аймаг: Ургамал сум орчмын нутаг нь ус намаг, говь, тал хээрийн гэсэн байгалийн хэд хэдэн үндсэн биотопуудтай учир экологийн бичил орчнууд нь олон зүйл амьтад орж ирж нутагших нөхцлийг бүрдүүлдэг.

Төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн хувьд Говь хээрийн бүсэд, газар зүйн мужлалын хувьд их нууруудын хотгортой зах залгаа нам дор газар оршино. Сумын нутаг дэвсгэр нь уул, толгод бүхий тал хээр газар юм.

Ургамал сумын нутагт туурайтан амьтдаас хар сүүлт байсан гэдэг боловч сүүлийн жилүүдэд харагдахаа больсон байна. Харин өндөр уулын бүсэндээ цөөн тоогоор аргаль янгир байдаг байна. Махчин амьтдаас чоно, үнэг, хярс амьдрахаас гадна хэвлээр явагч могой, гүрвэл нилээд элбэг үзэгдэнэ.

Ургамлын нөмрөг: Тус нутагт амьтан ургамлын аймгийн экосистемийн шинж төрх алдагдаж энэ хавийн ургамлын зүйлийн бүрдэлд хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд голлох болжээ. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт ургамлын аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны тэсвэртэй, дасан зохицох чадвартай ургамлууд байгаа болно.

Ургамал сум нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана (БНМАУ-ын үндэсний атлас, 1990).

Ургамал сумын нутаг дэвсгэрийн хувьд Говь хээрийн бүсэд, газар зүйн мужлалын хувьд их нууруудын хотгортой зах залгаа нам дор газар оршино. Сумын нутаг дэвсгэр нь уул, толгод бүхий тал хээр газар юм.

Ургамал сум нь ургамалжилтын ангиллаар тэгш тал газрын цөлийн хээр, тэгш талын хээр ба хуурай хээр бөгөөд Ургамал сумын нутаг дэвсгэрт дараах ургамлан бүлгэмдлүүд тархсан байна.Үүнд:

- Тэгш талын хээр ба хуурай хээр
- Тэгш тал газрын цөлийн хээр
- Нуур хөндийн нуга, марзлаг бэлчээр
- Сийрэг ургамалтай элс
- Сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр
- Намгархаг, нам дор газрын газрын бэлчээр
- Хээрийн нуга сийрэг
- Марзлаг бэлчээр

Дэд бүтэц, нийгэм эдийн засгийн байдал: Завхан аймаг нь Монгол улсын аймаг юм. 1923 онд байгуулагдсан. 24 сум, 114 багатай, 16580 хүн амтай (2021 оны эцсээр) бөгөөд хүн ам өсөж байна. Аймгийн төв Улиастай сум нь Улаанбаатар хотоос 1021 км-т оршдог. Улиастай сум нь Агьт, Баян-Улаан, Худаг, Жаргалант, Солоон, Хэрэмт, Зуслангийн ам, Товцог, Өндөр толгой уулын бэлчээр хиллэн Алдархаан сумын нутгийн төв хэсэгт оршдог.

Сумын хэмжээнд 79709 толгой малтайгаас 26 тэмээ, 2432 адуу, 2692 Үхэр, 33076 хонь, 41483 ямаа байна. Сумын хэмжээгээр нийт 79.9 мянган мал

тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 10.3 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 12.8 хувь байна. 200 малчин өрх, 623 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 14.6 хувийг эзэлж байна.

Сумын төсвийн нийт орлого нь 1343,7 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг 237,7 сая төгрөг, сумын өөрийн орлого 1106,0 сая төгрөгийн орлогоос бүрддэг. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 501,4 сая төгрөг байна. Нийт зардлын 59.8 хувь нь цалин, 6.6 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 33.6 хувийг нь бусад зардал эзэлж байна. Сумын хэмжээнд нийт 400 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 9,8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 237,7 сая төгрөг, орон нутагт 1106,2 сая төгрөг нийт 1343,7 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд 300-400 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Завхан баялаг ХХК, Нарантуул шим ХХК, Завхан хүнс группын салбар зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээ нь өсч байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Форсголд майнинг” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн байршил, техник-технологийн шийдэл төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” аргыг хэрэглэн үр дүнг нь доорх хүснэгтэд илэрхийлэв.

Хүснэгт № 6 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий	Уурхайн барилга байгууламж, ил уурхайгаар эвдрэлд орно	Төслийн талбайд	Их
Агаар	Олон хүний хөдөлгөөн, машин механизмын яндангаас гарах утаанаас болж агаар бохирдоно.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Хөрсөн бүрхэвч	Төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	Талбайн ургамал болон төслийн талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Ус	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгарагчаас ус бохирдож болзошгүй	Төслийн талбай орчим	Бага

III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.
- Ажиллагсдын агаарын чанарын стандарт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах дүрэм, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, зааварчилгаа өгөх, сургалт явуулах
- Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.
- Уурхайн тээвэрлэлтийн шороон замд том оврын тээврийн хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт ихээр бий болж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хаягдлын аж ахуйд эргэлтийн усны систем ашиглан үйлдвэрлэлийн хаягдалтай хамт хаягдсан усыг цэвэрлэн үйлдвэрлэлд эргүүлэн хэрэглэх шаардлагатай бөгөөд орон нутгийн хөрсний шингээлт, ууршилтын тайлангүй учир бусад үйлдвэртэй харьцангуйгаар технологийн нийт хэрэгцээт усны 80%-ийг эргүүлж ашиглахаар тооцоолсон байна. Тоног төхөөрөмжүүдийн цэвэрлэгээ болон бусад хэрэгцээнд бүх технологийн усны 15-20%-ийг хэрэглэнэ.

- Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.
- Ахуйн хатуу, шингэн хог хаягдалдаа зөв менежмент явуулаагүйгээс болж гүний ус бактер болон химийн бохирдолд орж болзошгүй.
- Технологийн хэрэгцээндээ шаардлагатай усыг газрын доорх уснаас ашиглаж байгаа тул газрын доорх усны нөөц баялаг багасах
- Ахуйн бохир хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Уурхайн техник хэрэгсэлд ашиглагдах шатах тослох материал алдагдсанаас болж хөрсөн бүрхэвч хүнд металлаар бохирдож улмаар гүний усанд нэвчих

III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороонд дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй
- Уг төсөл хэрэгжсэнээр тухайн төслийн талбай түүний орчмын бэлчээрийн талбай хомсодно.
- Хөрс хуулалт болон шимт хөрсийг хадгалах явцад хөрсний үржил шим нь алдагдах

III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.
- Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах ажлыг байнга хийнэ.
- Тус ордыг илуурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас амьтны зүйлд үзүүлэх шууд нөлөөлөл харьцангуй бага бөгөөд харин тус байгууламжийн бүтээн байгуулалтын үед хөрсөнд болон хөрсөн дээр амьдардаг хорхой шавж газар шорооны ажлын үед устах хөрстэй хамт зөөгдөх, дайжин алга болж болзошгүй.

- Тоосжилтоос үүдэн төслийн талбай түүний орчмын хөрс, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж ингэснээр амьтадын зүйлийн идэш тэжээлд дам байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлэх талтай.
- Хөрс, ургамлын нөмрөгт төслийн үйл ажиллагаанаас бохирдол үүсвэл тухайн ургамал, хөрснөөс хоол тэжээлээ олж иддэг амьтдын зүйлд дам байдлаар сөргөөр нөлөөлж амьтны зүйл хордож, үхэж үрэгдэж болзошгүй.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олборлолт явуулахад газар шорооны ажил хийгдэж тоосжилт үүсэж ургамлын нөмрөг тоосонд дарагдана.

IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Форсголд Майнинг” ХХК нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар шинэчлэн баталсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу “Цагаан толгой” алтны шороон ордны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Цагаан толгой” алтны шороон ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгалийн нөөц баялагийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

“Цагаан толгой” алтны шороон ордын 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тусгалаа.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Зардлын утга	Нэг жилийн зардал мян.төг
1	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	2200.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	8500.0
3	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	29500.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1830.0
5	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө	1700.0
6	Орчны шинжилгээний хөтөлбөр	7765.0
7	Удирдлага зохион байгуулалт	4050.0
	Нийт	55545.0

IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Цагаан толгой” алтны шороон орд ашиглах төслийн байгаль хамгаалах төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бохирдлыг багасгах, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг доорхи хүснэгтүүдэд бүрэн эхээр харуулав.

Хүснэгт № 7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин								
Хийн хаягдлаар агаар бохирдох	Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техник, хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх, машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх, машны тос маслыг солих	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбай		400.0	400.0	Уурхайн үйл ажиллагааны зардалаар	Ажил эхлэхийн өмнө /4 сард/	БОНБНУ
Орчны тоосжилт үүсэх	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах			300.0	300.0	Уурхайн үйл ажиллагааны зардалаар	Салхи ихтэй өдрүүдэд /56 удаа/	Агаарын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Байгаль цаг уурын аюулт үзэгдэл болохоос өмнө цаг агаарын урьдчилсан мэдээг Завхан аймгийн УЦУОШГазраас авч үйл ажиллагаандаа ашиглах			500.0	500.0	Уурхайн үйл ажиллагааны зардалаар	Жилийн туршид	БОНБНУ
Нийт дүн						1200.0		
Усны нөөц, чанар								
Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх	Уурхайн ус ашиглалттай холбоотой						1-р улиралд	Усны тухай хууль

Ус ашигласны төлбөрийг төлөх	бүхий л асуудлууд	-	-	-	Ус ашиглах дүгнэлтийн дагуу	1-р улиралд	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль
Ус бохирдуулсны төлбөр төлөх		-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	1-р улиралд	
Уурхайн эзэмшлийн 3 худгаас дээж авч шинжлүүлэх		ОХШХ-т тусгасан			200.0		
Нийт дүн					200.0		
Хөрс, ургамлын бүрхэвч							
Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	“Цагаан толгой” уурхайн талбайд аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл олгох, шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, хуулсан шимт хөрсийг тухайн талбайг нөхөн сэргээхэд буцааж ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгалах	Газар хөндөлт хийх хэмжээгээр	Мян.төг		-	Тайлант хугацаанд	БОНБНУ
Хөрсний чанар доройтох	Хөрсний шинжилгээний дүнгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж гадаад овоолгын талбайд хаях	Уурхайн нийт талбай	Мян.төг		-	Тухай бүрт	

Хөрсөнд бохирдол үүсэх	Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх	Уурхайн нийт талбай	Мян.төг		500.0	500.0	Тогтмол	
Ургамлын доройтол үүсэх	Мэргэжлийн байгууллагаар уурхай орчмын ургамлын судалгааг хийлгэх	Уурхайн нийт талбай	Мян.төг			Уулын ажлын төсөвт тусгагдсан	Жил бүр	
Нийт						500.0		
Амьтны аймаг								
Амьтны аймагт сөргөөр нөлөөлөх	Уурхайн аливаа үйл ажиллагаанаас зэрлэг амьтан эрсдэх, гэмтэх зэргээс хамгаалах арга хэмжээг авах, хяналт хийх	Уурхайн талбай дахь зэрлэг амьтад	Мян.төг		300.0	300.0	Сард нэг удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Мэргэжлийн байгууллагаар амьтны судалгааг хийлгэх	Ургамал суманд	Мян.төг				2023 онд	
Нийт								
Нийт						2200.0		

IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд зааснаар төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгахаар заасан тул Цагаан толгой алтны шороон орд ашиглах төслийн нөхөн сэргээлтийн товч төлөвлөгөөг зардлын хамтаар Хүснэгт 9-т үзүүлэв.

Хүснэгт № 8 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Цагаан толгой уурхайн гадаад овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийх	га	3.92	Үйл ажиллагааны зардалаар	5-11 саруудад	MNS 5917:2008
	Цагаан толгой уурхайн дотоод овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийх	га	13.87			
Биологийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт хийж дууссан шимт хөрс	га	2	8500.0	5-6 саруудад	MNS 5918:2008
	Техникийн нөхөн сэргээлт хийж дууссан биологийн нөхөн сэргээлт	а	2			
Нийт дүн					8500.0	

IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Дүйцүүлэн хамгаалах зорилго

Дүйцүүлэн хамгаалах асуудал нь нөлөөллийг бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах аргаар хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Энэхүү менежментийн төлөвлөгөө нь дараах зорилготой байна.

- Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хүрээлэн буй орчин болон биологийн олон янз байдлыг хамгаалах.
- Үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ ба тайлагнах журмыг тодорхойлох;
- Урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд ба цаашдын шаардлагатай судалгаа шинжилгээний хэрэгцээг тодорхойлох зэрэг болно.

Хүснэгт № 9 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт, Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам
Ургамал сумын ЗДТГ-тай хамтран Дүйцүүлэн хамгаалалт хийх талбайг сонгон иргэдийн нийтийн хурлаар батлуулах	Төслийн талбай	1	-	-	2-11 сард	Холбогдох арга, аргачлалууд
Дүйцүүлэн хамгаалалтын талбайн амьтны мониторинг судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Төслийн талбай	1	10000.0	10000.0	6-9 сард	
Зэрлэг амьтны амтдрах орчныг тэтгэх зорилгоор тухайн сумын нутагт байрших Янгир ямаа, Цагаан зээр зэрэг амьтанд биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Суманд	4 удаа	1500.0	1500.0	2023 онд	Арга зүйн зөвлөгөө
Говийн гайхамшигт 6 амьтныг олон нийтэд таниулах, хамгаалах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Суманд	Улирал бүр	3000.0	3000.0	2023 онд	
2022 онд тарьсан 2 га газарт нөхөн тарилт хийх, 3-н жилийн арчилгаа, усалгааг тогтмол хийх	Уурхайн талбайд	2 га	5000.0	5000.0	2023 онд	Мод услах агротехник
2023 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд батлагдсан модны хуваарийн дагуу Хүнгүйн голын дагуу 2 га газарт мод тарих	Суманд	2000ш	10000.0		2023 онд	Мод тарих агротехник
Лицензийн талбай дотор эвдэгдсэн газрын судалгааг хийж БОАЖГазарт ирүүлэх			Үйл ажиллагааны зардалаар			
“Нөхөн сэргээлт”-2024 арга хэмжээний хүрээнд лиценжийн талбай дотор эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийж сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгөх			Үйл ажиллагааны зардалаар			
Нийт дүн				29500.0		

IV.4 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө

“Форс голд майнинг” ХХК-ны MV-020628 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан толгой алтны шороон орд төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй тул нүүлгэн суурьшуулах, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй.

IV.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч бусад уурхайнуудын туршлагаас харахад нутгийн иргэд амар хялбар байдлаар ашиг орлого олох, олсон олдворуудаа чанар болон ач холбогдлыг хэр үнэ хүрэх байдлаар нь үнэлдэггүй ба эдгээр олдвор, эд зүйлсэд учрах хор хөнөөл, гэмтлийг үл хайхран аль болох амар хялбар аргаар ухаж гарган авдаг тохиолдолд цөөнгүй байдаг.

IV.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

“Цагаан толгой” алтны шороон орд ашиглах төсөл нь дотоод аюулгүй ажиллагаандаа OHSAS18000 буюу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах нь зүйтэй. Уурхайн гэнэтийн ослын эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг дэлгэрэнгүй авч үзсэн тул доорх хүснэгтэд хураангуй байдлаар харуулав.

Хүснэгт № 10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Газар хөдлөлт		Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	600.0	Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аянга цахилгаан		Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аадар бороо		Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө, нэг удаа
Шороон шуурга	Агаарын чанарт хяналт шинжилгээ явуулах,	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай		Төслийн хугацаанд байнга
Үер		Гадаргын усны урсцыг өөрчлөх, үерийн далан шуудуу татах, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Төслийн талбай		Төслийн хугацаанд, аль болох хур борооны улирлаас өмнө
Байгалийн аюул, гамшгаас эсрдэл учрах	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Байгалийн аюул, гамшгаас эсрдлээс урьдчилан сэргийлэх	Уурхайн хэмжээнд	200.0	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт
Халдварт өвчин	Үндэсний болон бүсийн халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөөтэй холбоо тогтоох	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай	350.0	Төслийн хугацаанд, жил бүр
Нефт болон химийн аюултай бодис асгарах	Бохирдсон хөрсийг саармагжуулах, эрүүлжүүлэх талбайд зөөн хураах, асгаралтын эсрэг журмуудыг боловсруулж мөрдөх. ажилчидад асгаралтын талаар сургалтуудыг тогтмол өгөх.	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг		Төслийн хугацаанд байнга

<p>Уурхайн хана, овоолгын нуралт</p>		<p>Доголын болон овоолгын нурж болзошгүй хэсгүүдийг цаг тухайд нь унагаж байхын зэрэгцээ нурах болон гулсаж болзошгүй газруудад анхааруулах тэмдэг хадна. Уурхайн усыг байнга шүүрүүлэн хөрс, олборлолтын догол, мөргөцгийг усгүй хуурай байлгана. Уурхайг хур тунадасны ус үерээс хамгаалан, ус орж ирэх бүх талаар нь усны шуудууг татсан байх. Овоолгын талбайг байнга тэгшлэн, арчилж байхаас гадна овоолгыг цас бороо, үерийн уснаас хамгаалах ус орж ирэх боломжтой бүх талаас нь шуудуу байгуулах.</p>	<p>Төслийн талбай</p>	<p>280.0</p>	<p>Төслийн хугацаанд</p>
<p>Хаягдлын болон эргэлтийн ус хадгалах далан хаалт сэтрэх</p>		<p>Мэргэшсэн геотехникийн инженер жил бүр далан, хаалтуудад үзлэг шалгалт хийх, далангийн усны түвшинд пьезометр ашиглаж байнга хяналт тавих, ус түвшин огцом багассан тохиолдолд шалтгааныг тогтоож, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай.</p>	<p>Төслийн талбай</p>	<p>300.0</p>	<p>Төслийн хугацаанд жил бүр</p>
<p>Автомашин осол</p>		<p>Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах. Байгалийн гамшигт үзэгдэл, үзэгдэх орчин хязгаарлагдах үед хэрэгжүүлэх онц байдлын журам боловсруулж мөрдөх</p>	<p>Төслийн талбай</p>	<p>100.0</p>	<p>Төслийн хугацаанд</p>
<p>Нийт зардал</p>				<p>1830.0</p>	

IV.7 Хог хаягдлын менежмент

Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна. Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаана. Ашигласан тосыг битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.

Уурхайн хотхонд түр хог хаягдлын цэгийг орон нутгийн зөвшөөрөлтэйгөөр байгуулсан ба түр хогийн цэгт хог хаягдлыг хаяхдаа ялган ангилах ба дараах 2 өнгөөр ялгасан хогийн савнуудыг энгийн болон хуванцар сав хаях зориулалтаар байрлуулна.

Хаягдал зайлуулах нүх/савыг сард нэгээс доошгүй удаа ариутгах ба бие засах газар, шүршүүрийг өдөр бүр цэвэрлэж, ариутгана. Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар бохир усны нүх, сав, бие засах газрыг ариутган булж тэгшлэн нөхөн сэргээнэ. Бага агуулгатай эфелийн овоолгын бүртгэл мэдээллийг хөтөлж уурхайн хаалт нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд MNS 5917:2008 стандартад заасны дагуу 20 градусаас ихгүй налуутайгаар хэлбэршүүлж орон нутгийн удирдлагад холбогдох газрын зураг, мэдээллийн хамт хүлээлгэн өгнө.

Ажилчдын хариуцлагагүй байдал, машин техникийн эвдрэл гэмтэл зэргээс хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан авч, тусгаарлагч гадаргуу дээр овоолон, 18-22%-ийн хлорт уусмалаар бороожуулж, нефтийн бүтээгдэхүүний агуулга 0.07 мг/кг-аас ихгүй, 4 этилт хар тугалганы хэмжээг 0.05 мг/кг-аас ихгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд буцаан байршуулна.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаар зохицуулагдаж байна.

Энэхүү төслийн хүрээнд алт олборлох явцад төсөл хэрэгжүүлэгч дараах эрх эзэлж үүрэг хүлээнэ.

- Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;
- Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;

- Хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- Аюултай хог хаягдлыг бусад төрлийн хог хаягдалтай хамт тээвэрлэхгүй байх;
- Хог хаягдлыг зориулалтын саванд хийж, цуглуулах

Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ШТМ асгарсан тохиолдол тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд мэдээлэх, уурхайн дотоод журамд хог хаягдлыг ангилах талаар тусган ажиллана. Төсөл хэрэгжих хугацаанд үүссэн хатуу хог хаягдлыг дээрх зөвлөмжийн дагуу зайлуулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.

Хүснэгт № 11 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг устгах	Хог хаягдлыг зайлуулах хугацаа	Нийт зардал /мян.төг/
Ахуйн хэрэглээний хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарах ахуйн хог хаягдлыг /хуванцар, шил, гялгар уут, төмөр бусад/ гэсэн 5 төрлөөр ангилан ялгаж дахивар хаягдал /шил, хуванцар, гялгар уут, төмөр/ зэргийг дахин боловсруулах эрх бүхий газарт шилжүүлэх	Жилд 1-2 удаа	
	Үйл ажиллагаанаас үүссэн дахин боловсруулах үйлдвэрт шилжих боломжгүй хаягдлыг сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт сумтай хог хаягдлын гэрээ байгуулан төлбөр хураамж төлж хүргэх	Улирал бүр	200.0
	Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал бүрийг нэр төрлөөр бүртгэл хөтлөх	Сар бүр	-
	3 тасалгаат хогийн савыг байрлуулах /хотхон болон төслийн гадна талбай/	Төсөл эхлэхээс өмнө	500.0
Аюултай хог хаягдал	Үйл ажиллагаанаас үүсэх аюултай хаягдал /аккумулятор, зай баттерей, принтрийн хор, тосол тосолгооны арчих тослох материал,	Жил 1-2 удаа	

	техникийн хаягдал тос гэх мэт/-ийг дахин боловсруулах эрх бүхий үйлдвэртэй гэрээ байгуулан хуулийн хугацаанд шилжүүлэх		
	Хог хаягдлын мэдээ тайланг сар бүр БОАЖГазарт ирүүлэх	Сар бүр	-
	Техникийн хаягдал тосыг солих явцад хөрсөнд нэвчихгүй арга хэмжээг авч, тусгай газрыг цементлэн талбай гаргах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	600.0
	Эх үүсвэрээс гарах Хог хаягдлыг /аюултай болон энгийн/ байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр түр хадгалах цэгийг тогтоох	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	400.0
Нийт зардал			1700.0

IV.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Цагаан толгой алтны шороон орд ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Форс голд майнинг”ХХК-д өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Форс голд майнинг” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах

нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч ОХШХ-г хэрэгжүүлэхдээ хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэх ба хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 12 Орчны шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал Мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар					
Тоосжилт (PM ₁₀ , PSM, PM _{2,5})	Хяналтын цэгүүдэд	5, 8-р саруудад	50,0	50.0	MNS4585:2016 Агаарын чанар, Суурин болон зөөврийн багажаар зааврын дагуу дээж авах
Тоосжилтын тархалт	Хяналтын цэгүүд	5-9 саруудад	60.0	60.0	EPA хүлцэх хэмжээ, Зориулалтын бортого ашиглан идэвхгүй аргаар тооцох
Агаарын хэм, салхины хурд, чийгшил, хур тунадас	Уурхайн цаг уурын станц	Жилийн туршид	-	-	Мэдээнд боловсруулалт хийх
Дуу шуугиан	Хяналтын цэгүүд	5-9 саруудад	40,0	40.0	MNS4585:2016 Агаарын чанар, Зөөврийн багаж ашиглан хэмжих
-SO ₂ Хүхэрлэг хий -NO ₂ Азотын давхар исэл	Хяналтын цэгүүд	5-9 саруудад	100,0	100.0	MNS4585:2016 Агаарын чанар, Зөөврийн багажаар зааврын дагуу хэмжих, дээж авах
Нийт			250.0	250.0	
Усан орчин					
Химийн ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Гадаргын уст цэг: үүсмэл нуур	Дотоодын хяналт шинжилгээний хүрээнд улиралд нэг удаа (усны шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг өөрчилж	Усны дээж авах сав, хээрийн хэмжилтийн багаж (pH/EC/TDS meter, TDS-3) зэргийг ашиглан дээж авах ба дээжийг	100.0*3=300.0 мян.төг	MNS ISO 5667-11:2000 Гүний уснаас дээж авах MNS 0900:2018 Ундны ус эрүүл ахуй

	Унд ахуйн хангамжийн худагт	болно) Хөндлөнгийн хяналт шинжилгээний хүрээнд жилд нэг удаа.	итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлнэ	100,0*3=300,0 мян.төг	
Нийт				600.0	
Хөрсний төлөв байдал, бохирдолт					
Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg	Шимт хөрсний овоолго, уурхайн карьер, баяжуулах үйлдвэр-1, замын тоосжилт хянах цэг-2, хөрсний овоолго-1, ажилчдын тосгон-1	Дотоодын хяналт шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг өөрчилж болно) Хөндлөнгийн хяналт шинжилгээний хүрээнд жилд нэг удаа. Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ 45.0мян.төг *3= 135,0 мян.төг			MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
Агрохими	Замын тоосжилт хянах-2, хөрсний овоолго,		50.0*2=100.0		MNS 3310:1991 Хөрсний агрохимийн үзүүлэлт
Хүнд металл	Эфил, гаалын овоолго, баяжуулах үйлдвэр, шатахуун түгээх газар, засварын төв		65*2=130.0		MNS 5850:2018.Хөрсний чанар. MNS 3298:1990 Хөрсний дээж авах
1 см ³ дэх нийт бичил биетний тоо,	Ахуйн хог хаягдлын цэг		150.0		Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3297 - 1991
Нийт			515.0		
Ургамал					

<p>Ургамлын газрын дээд болон доод массын дээжлэлт хийх</p>	<p>Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүдийг сонгон авч ургамлын дээд болон доод массын дээж авч лабораторийн шинжилгээнд явуулж, агууламжийг харьцуулан гаргах</p>	<p>Жилд нэг удаа (6-7 сард)</p>	<p>Батлагдсан арга зүйн дагуу жилд хоёр удаа</p>	<p>600.0</p>	<p>Батлагдсан арга зүйн дагуу</p>
<p>Хяналтын талбай бүрт 30 метрийн урттай трансектийг давтамжтай тавьж, трансект тус бүрт он сар өдөр, шалгасан хүний нэр, трансектийн бүртгэлийн дугаар, газрын хэвшил, ургамлын төрөл зүйл зэрэг мэдээллүүдийг авна. Мөн ургамлан нөмрөгийн дээд доод бүрхэц, ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдэлд эзлэх хувь зэргийг гаргана. Үүнд: дундаж өндөр см, биомасс, кг/га Хяналтын талбай бүрийн (25x25м, 1x1м, 10x10м) ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэц, бүлгэмдэлд эзлэх % Хяналтын явцад төслийн талбайд жилийн дундаж хур тунадсыг хэмжиж, тухайн жилийн ургамлын биомасстай хур тунадасны хэмжээг харьцуулах,</p>	<p>Төслийн байгууламжийн талбай дахь судалгааны цэг Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэг</p>	<p>Төсөл хэрэгжилтийн явцад, нөхөн сэргээлтийн шатанд жилд нэг удаа (6-7 сард)</p>	<p>Батлагдсан арга зүйн дагуу</p>	<p>800.0</p>	<p>Батлагдсан арга зүйн дагуу</p>
<p>Нийт</p>				<p>1400.0</p>	
<p>Амьтны аймаг</p>					

Туруутан амьтдын байршил нутаг, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөлхөгчдийн нягтшил, зүйлийн бүрдэл, мэрэгчдийн нягтшил зэргийг тогтоох	Төслийн талбайн болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Жилд 2 удаа 5 болон 10 сард	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй	5000.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
Жил бүр шувуудын нүүдлийн үеэр ажиглалт, мониторинг хийх.	Төслийн талбай болон түүний орчмын уст цэг, мод бутлаг ургамал бүхий амьдрах орчинд	Жил бүрийн хавар (4.20-6.20), намар (8.20-9.20)	Ажиглах бүртгэх		Ажиглах бүртгэх
Нийт				5000.0	
Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал					7765.0

V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана.

“Форсголд майнинг” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Компаний удирдлага
2. ХАБЭА-н инженер

Эдгээр 2 хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайланг орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, болон нутгийн иргэд, ТББ хянаж оролцож байхаар тусгав.

Цагаан толгой алтны шороон орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлэх шаардлагатай .

Хүснэгт № 13. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ, цар хүрээ	Хугацаа, давтамж	Зардал, мян.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	50.0
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Төслийн нийт хугацаанд	300.0
3.	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	600.0
4.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	Төслийн нийт хугацаанд	900.0
5.	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс	200.0
6.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Завхан аймгийн ЗДТГ-г хүргэн өгч байх	Жил бүрийн 12 сард	-
7.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	2000.0

8.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Төслийн хугацаанд	2024 онд
9.	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	Төслийн хугацаанд	2024 онд
Нийт зардал			4050.0

Зардлыг тухайн үеийн төлөвлөгөөт зардлаар тооцно.

Хүснэгт № 14 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

№	Арга хэмжээ	Хугацаа	Давтамж
II-1	Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).	2023	Байнгын
II-2	Байгаль орчны бодлого, зорилго, зорилт, хууль эрхзүйн болон бусад шаардлагуудын дагуу үйл явцыг хянаж хэмжих ба үр дүнг тайлагнах	2023	Жил бүр
II-3	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр
II-4	Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компаний хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;	2023	Жил бүр
II-5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн явцын талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тайлагнах.	2023	Жил бүр
II-6	Төслөөс үүсч болзошгүй нөлөөллийг хамгийн бага байлгах буюу нөлөөлөлгүй байлгах үүднээс соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;	2023	-
II-7	Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдалдал болон бусад мэдээллийг оролцогч талууд болон орон нутгийн удирдлагуудад мэдээлж байх;	2023	Жил бүр
II-8	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2023	-
II-9	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах, тэдний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг гэрээнд тусгах	2023	Тухай бүрт нь

Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь:

Төсөл хэрэгжүүлэгч “Форсголд майнинг” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар,

сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт № 15 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль Орчин Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс	Улаанбаатар хот
Завхан аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жилийн эцэст	Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах	Завхан аймаг
Ургамал сумын Засаг даргын тамгын газарт	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Хагас жил, жилийн эцэст	Хамтран ажиллах	Ургамал сум